



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 462


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт, Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/79 тоот тушаал, 2016 оны А/87 тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон "Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам", 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн А/194 тоот "Журамд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай", А/195 тоот "Босго оноо тогтоох тухай" тушаал, Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/195 тоот "Их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарим зохицуулалт хийх тухай" тушаал, "ШУТИС-ийн дүрэм"-ийн 4.14.10, 10.2 дахь заалтууд, Захирлын зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын хөтөлбөрт 2020-2021 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын дагуу элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахыг Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн албаны дарга (Д.Батдорж), Мэдээллийн технологийн албаны дарга (Р.Төрбат), бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.
3. Элсэлтийн үйл ажиллагаа, журам сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулахыг Сургалтын хөтөлбөр, бүртгэлийн албаны дарга (Д.Батдорж), Маркетинг, олон нийттэй харилцах албаны дарга (Х.Отгон-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.
4. Элсэлтийн ажлыг чанартай зохион байгуулж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Х.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

367040397

2

ШУТИС-ийн захирлын 2020 оны 04-р сарын
24-ний өдрийн 462 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



	БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ ШУТИС-СҮ-ЖУ11	Эхний хэвлэлт	1991.05.01
		Өөрчилсөн огноо	2020.04.23
		Өөрчлөлтийн дугаар	29

БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

(2020-2021 оны хичээлийн жил)

Боловсруулсан:

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БҮРТГЭЛИЙН АЛБА

Хянасан:

СУРГАЛТ, ОЮУТНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ
ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ийн ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ийн ЗАХИРАЛ



АГУУЛГА

АГУУЛГА.....	3
Нэг. Нийтлэг үндэслэл.....	4
ХОЁР. Хамрах хүрээ.....	4
ГУРАВ. Норматив эш таталт.....	4
ДӨРӨВ. Нэр томъёоны тодорхойлолт.....	4
ТАВ. Эрх мэдэл, үүрэг хариуцлага.....	5
ЗУРГАА. Элсэлтийн бүртгэл, баталгаажуулалт.....	6
6.1 Элсэгчдэд тавигдах шаардлага.....	6
6.2 Элсэлтийн бүртгэл.....	7
6.3 Ур чадварын шалгалт.....	8
6.4 Эрэмбэлэлт, онооны жагсаалт.....	8
долоо. Мэргэжил сонголт.....	8
7.1 Өдрийн анги.....	8
7.2 Шууд элсэлт, цагийн /эчнээ гараг, орой/ элсэлт.....	9
найм. Суралцах гэрээ.....	9
8.1 Шинээр элсэгчийн бүртгэл.....	9
8.2 Элсэгчдэд олгох тэтгэлэг.....	10
хавсралт 1. Үйл явцын Зураглал.....	11
хавсралт 2. Хөтөлбөр, Мэргэжил.....	13